

**ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

2025 оны 06 дугаар сарын 06

Улаанбаатар хот

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
<p style="text-align: center;">Зорилго 1. Хүний нөөцийн бодлого тодорхойлох, төв болон хийлийн боомт, орон нутаг дахь бүтцийн нэгжийн уялдаа холбоог хангах, хууль эрх зүй, дотоод хяналт, аюулгүй байдал, олон нийтийг мэдээллээр хангах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах (Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр 2.5, 2.6, 6.4.11, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 2.6.2.1, 6.4.11.1)</p>							
<p style="text-align: center;">Зорилт 1. Хүний нөөцийн бодлого, хэрэгцээг оновчтой тодорхойлох, хүний нөөц бүрдүүлэх, хуваарилах, дүгнэх тогтолцоог бий болгож, мэргэшсэн чадварлаг албан хаагчдын нөөцийг бүрдүүлэх, сургах, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг зохион байгуулах.</p>							
1	Арга хэмжээ 1.1. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөө батлан хэрэгжилтийг хангах	Урсгал зардал	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	91.4	100	<p>Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023-2030 он) болон Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2024 оны хэрэгжилтийг khutulbur.iaac.mn цахим хуудсанд 01 дүгээр сарын 28-ны өдөр илгээж, нэгдсэн тайланг 01 дүгээр сарын 28-ны өдрийн 01/247, 01/248 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Авлигатай тэмцэх газарт тус тус хүргүүлсэн.</p> <p>Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023-2030)-ийг хэрэгжүүлэх 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Гадаадын иргэн, харьяатын газраас авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг тус тус байгууллагын даргаар батлуулж, Захиргаа, удирдлагын газрын 02 дугаар сарын 06-ны өдрийн 02/14 дотоод албан бичгээр төв, орон нутаг дахь нэгжийн дарга нарт хүргүүлэн байгууллагын www.immigration.gov.mn цахим хуудсанд нээлттэй байршууллаа.</p> <p>Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Авлигаас урьдчилан сэргийлэх, Эрсдэлд суурилсан</p>	70

1	2	3	4	5	6	7	8
						<p>авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөө хүргүүлэх болон эрчимжүүлэхтэй холбоотой чиглэлийг 02 дугаар сарын 06-ны өдрийн 02/14, 05 дугаар сарын 23-ны өдрийн 02/69 дотоод албан бичгээр тус тус төв, хилийн боомт, орон нутаг дахь нэгжүүдэд хүргүүлж ажилласан. Нийтдээ 2 зөвлөмж, чиглэл өгсөн дотоод албан бичиг 3 удаа хүргүүлж, арга зүйн зөвлөгөө дэмжлэгээр хангасан. Эхний хагас жилийн дүнгээр Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх 3 төлөвлөгөө, 1 чиглэлийн хэрэгжилт 90 хувьтай.</p>	
2	<p>Арга хэмжээ 1.2. Эрсдэлд суурилсан авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө батлан хэрэгжилтийг хангах</p>	Урсгал зардал	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	100	<p>Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр болон байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд “Эрсдэлд суурилсан авлигын эсрэг төлөвлөгөө”-г 02 дугаар сарын 05-ны өдөр байгууллагын даргаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Төлөвлөгөөг байгууллагын чиг үүрэгт хамааралтай 3 зорилтын хүрээнд 18 үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд эхний хагас жилийн дүнгээр хэрэгжилт 80 хувьтай.</p> <p>Төлөвлөгөөний хүрээнд Виз, зөвшөөрлийн газрын албан хаагчдын ачааллыг бууруулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж байгууллагад чирэгдэлгүй, шуурхай хүргэх зорилгоор байгууллагын даргын 03 дугаар 07-ны өдрийн А/114, 03 дугаар сарын 26-ны өдрийн А/145, 03 дугаар сарын 31-ний өдрийн А/158 дугаар тушаалаар тус тус виз, визийн зөвшөөрөл, Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суугаа гадаадын иргэний оршин суух зөвшөөрөл сунгах, оршин суух үнэмлэх дахин авах, паспортын мэдээлэл өөрчлөх, хаягийн өөрчлөлт, оршин суух зөвшөөрлийн хасалт хийлгүүлэх хүсэлтийг хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн албан хаагчаар цахимаар хянуулахаар шийдвэрлэсэн.</p> <p>Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэн, хуулийн этгээдийг татан оролцуулах замаар байгууллага, нэгжийн албан тушаалтны үйл ажиллагаанд тавих олон нийтийн хяналтыг бүрдүүлэх зорилгоор байгууллагын</p>	70

1	2	3	4	5	6	7	8
						даргын 05 дугаар сарын 27-ны өдрийн А/247 дугаар тушаалаар “Олон нийтийн хяналтад хамруулах чиглэл”-ийг баталсан. Тушаалыг төв болон хилийн боомт, орон нутаг дахь нэгжүүдэд Захиргаа, удирдлагын газрын 05 дугаар сарын 27-ны өдрийн 02/72 дотоод албан бичгээр хүргүүлсэн.	
3	Арга хэмжээ 1.3. Гадаадын иргэн, харьяатын газрын “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр” (2025-2028)-ийг шинэчлэн батлах	Урсгал зардал	Тушаалын огноо, дугаар	-	1	Гадаадын иргэн, харьяатын газрын “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны 2025-2028 оны хөтөлбөрийн төсөлд Захиргаа, удирдлагын газрын 02 дугаар сарын 12-ны өдрийн 02/18 дугаар дотоод албан бичгээр зохион байгуулалтын нэгжүүдээс санал авч, нэгтгэн Даргын дэргэдэх зөвлөлийн 02 дугаар сарын 25-ны өдрийн 1 дүгээр хурлаар хэлэлцүүлээ. Хөтөлбөрийг 4 зорилтын хүрээнд 30 арга хэмжээг зохион байгуулахаар байгууллагын даргын 02 дугаар сарын 25-ны өдрийн А/107 дугаар тушаалаар батлуулж, байгууллагын цахим хуудас болон төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны нэгдсэн системд нээлттэй байршуулсан.	90
4	Арга хэмжээ 1.4. Төрийн тусгай албаны тушаалын сул орон тоог хууль тогтоомжийн дагуу нөхөх	Урсгал зардал	Сонгон шалгаруулалтын тоо	7	7	Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 4.2-т заасны дагуу төрийн тусгай албаны гүйцэтгэх 18 албан тушаалын сул орон тооны 3 удаагийн зарыг байгууллагын www.immigration.gov.mn цахим хуудсанд нээлттэй байршуулсан. Дээрх журмын 4.3, 4.4-т зааснаар төрийн жинхэнэ албан хаагчдаас нөхөгдөөгүй 8 сул орон тоог Төрийн албаны зөвлөлд захиалга хүргүүлэн www.csc.gov.mn цахим хуудсанд нээлттэй байршуулж, 2 удаагийн сонгон шалгаруулалт зохион байгуулаад байна. Сонгон шалгаруулалтад 2 удаа нээлттэй зарласан Хойд бүс дэх газрын мэдээллийн технологийн мэргэжилтэн, Мэдээллийн технологийн хэлтсийн сүлжээний болон өгөгдлийн сан хариуцсан мэргэжилтний 3 сул орон тоонд шаардлага хангасан иргэн бүртгүүлээгүй, хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн хяналтЗын улсын байцаагчийн 2 орон тоонд өрсөлдсөн иргэдийн шалгалтын дүн босго оноонд хүрээгүй.	50
5	Арга хэмжээ 1.5.	Урсгал	Төлөвлөгөөний	90	100	Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах 2025	90

1	2	3	4	5	6	7	8
	Албан хаагчийн нийгмийн баталгааг хангах үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөө батлан хэрэгжилтийг хангах	зардал	хэрэгжилтийн хувь			<p>оны төлөвлөгөөг Даргын дэргэдэх зөвлөлийн 02 дугаар сарын 25-ны өдрийн 1 дүгээр хурлаар хэлэлцүүлж, байгууллагын даргаар батлуулсан. Төлөвлөгөөг байгууллагын цахим хуудас болон төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны нэгдсэн системд нээлттэй байршуулсан.</p> <p>Төлөвлөгөөний хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулав.</p> <p>Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолын дагуу төв, хилийн боомт орон нутаг дахь нэгжийн төрийн тусгай болон төрийн үйлчилгээний нийт 266 албан хаагчийн албан тушаалын үндсэн цалинг байгууллагын даргын 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/12 дугаар тушаалаар шинэчлэн тогтоолоо.</p> <p>Байгууллагын даргын 2024 оны А/407 дугаар тушаалаар “Гадаадын иргэн, харьяатын газрын албан хаагчийг зайнаас ажиллуулах журам”-ыг батлуулж, ажлын онцлог, чиг үүргээс хамаарч зохион байгуулалтын нэгжийн даргын баталсан хуваарийн дагуу 38 албан хаагчийг 7 хоногийн 1 өдөр зайнаас ажиллуулж байна.</p> <p>Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын 4.17, 4.18, 4.19-р зүйлд заасны дагуу албан хаагчийн шалтгаан нөхцөлийг нь харгалзан 47 албан хаагчид давхардсан тоогоор олговортой чөлөө 36, олговоргүй чөлөө 23 нийт 59 удаа олгосон байна.</p> <p>Байгууллагын даргын 2025 оны Б/16, Б/18, Б/79 дүгээр тушаалаар гэр бүлийн гишүүн нь нас барсан 3 албан хаагчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх мөнгөн тусламж олгуулсан.</p>	
6	Арга хэмжээ 1.6. Монгол Улсын хилийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу хилийн боомтод үүрэг гүйцэтгэх орон нутаг дахь нэгжийн ачааллыг тэнцвэржүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх,	Урсгал зардал	Хамрагдсан нэгжийн тоо; Зохион байгуулалтын ажлын гүйцэтгэлийн хувь	-	7/100	<p>Байгууллагын даргын баталсан 01-02/31 удирдамжийн дагуу 06 сарын 03-ны өдөр "Төрийн байгууллагын процессын дахин инженерчлэл" сэдэвт сургалтыг Удирдлагын академийн багш, доктор, дэд профессор Б.Нарантулгатай хамтран зохион байгуулав. Сургалтад төв, хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн 150 орчим албан хаагчийг хамруулсан.</p> <p>Виз, зөвшөөрлийн газрын албан хаагчдын ажлын ачааллыг бууруулж, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор виз, визийн зөвшөөрөл, албан болон хувийн</p>	90

1	2	3	4	5	6	7	8
	үйлчилгээний шуурхай, ил тод байдлыг хангах зорилгоор зохион байгуулалтын бүтэц, ажил үүргийн хуваарьт өөрчлөлт оруулж, процессын дахин инженерчлэлийг үе шаттай хэрэгжүүлэх					<p>хэргээр оршин суугаа гадаадын иргэний оршин суух зөвшөөрөл олгох, сунгах, оршин суух үнэмлэх дахин авах, паспортын мэдээлэл өөрчлөх, хаягийн өөрчлөлт, оршин суух зөвшөөрлийн хасалтын хүсэлтийг хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн 6 газар, 4 хэлтсийн албан хаагчдаар гүйцэтгүүлэхээр байгууллагын даргын 2025 оны А/63 тушаалаар 31, А/114 тушаалаар 8, А/145 тушаалаар 43, А/158 тушаалаар 14, нийт 96 албан хаагчийг хүсэлтийг цахим системд шалгах эрх олгосон.</p> <p>Мөн төвийн үндсэн чиг үүргийн нэгжийн албан хаагчдын ажлын ачааллыг бууруулах, хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн албан хаагчдыг ажлын байранд сургаж, дадлагажуулах зорилгоор Виз зөвшөөрлийн газарт 24, Зөрчил шалган шийдвэрлэх газарт 11, Зөвлөгөө, мэдээллийн хэлтэст 2, Мэдээллийн технологийн хэлтэст 1, орон нутгийн Дорноговь аймаг дахь газарт 1, нийт 39 албан хаагчийг байгууллагын даргын 8 удаагийн тушаалаар 1-3 сарын хугацаатай сургалаа.</p>	
7	Арга хэмжээ 1.7. Албан хаагчдын амьжиргааны нөхцөлийг харгалзан орон сууцны урьдчилгаа, зээлийн болон түрээсийн төлбөрийн дэмжлэг үзүүлэх	Урсгал зардал	Хамрагдсан албан хаагчийн тоо	26	25	Хэрэгжүүлэх хугацаа болоогүй	
8	Арга хэмжээ 1.8. Байгууллагын 2025 оны сургалтын төлөвлөгөө батлан хэрэгжилтийг хангах	Урсгал зардал	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	93.3	100	Төрийн албан хаагчийн 2025 оны сургалтын төлөвлөгөөг 6 арга хэмжээний хүрээнд 35 үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр батлуулж, холбогдох сургалтуудыг зохион байгуулж байна. Төлөвлөгөөний дагуу эхний хагас жилд төв, хилийн боомт орон нутгуудтай хамт нийт 42 удаагийн сургалтыг бусад байгууллагатай хамтран зохион байгуулж, давхардсан тоогоор 1800 гаруй албан хаагчийг хамруулаад байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувьтай хэрэгжсэн байна.	100

1	2	3	4	5	6	7	8
9	Арга хэмжээ 1.9. Удирдлагын академийн холбогдох сургалтад албан хаагчдыг хамруулах	Урсгал зардал	Богино, дунд, мэргэшүүлэх багц сургалтад хамрагдалтын хувь	90	100	Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 2, төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 7, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 3, эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1, нийт 13 албан хаагчийг хамруулсан.	100
10	Арга хэмжээ 1.10. Удирдах албан тушаалтны цугларалт зохион байгуулах	Урсгал зардал	Гүйцэтгэлийн хувь	-	100	Байгууллагын даргын 01 дүгээр сарын 29-ний өдрийн “Удирдах албан тушаалтны нэгдсэн сургалт зохион байгуулах тухай” А/59 дүгээр тушаалаар 02 дугаар сарын 03, 04-ний өдрүүдэд төв, хилийн боомт, орон нутаг дахь газар, хэлтсийн удирдах албан тушаалтны цугларалтыг зохион байгуулсан. Цугларалтад төвийн нэгжийн дарга, хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн дарга, хяналтын улсын ахлах байцаагч, виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн, захиргааны ахлах мэргэжилтэн зэрэг 34 албан хаагч хамрагдлаа. Сургалтын үр дүнг 02 дугаар сарын 07-ны өдрийн 01-02/08 илтгэх хуудсаар удирдлагад танилцуулсан.	100
11	Арга хэмжээ 1.11. Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх А3 сургалтын гэрчилгээтэй хүний нөөцийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах	Урсгал зардал	Гүйцэтгэлийн хувь	-	100	Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх А3 сургалтын гэрчилгээтэй хүний нөөцийг бүрдүүлэх зорилгоор Захиргаа, удирдлагын газрын даргын 01 дүгээр сарын 10-ны өдрийн “Чиглэл хүргүүлэх тухай” 02/05 дугаар дотоод албан бичгээр төрийн жинхэнэ албан хаагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох “Худалдан авах, ажиллагааны мэргэшүүлэх А-3 сургалтад хамрагдахыг тусгуулах чиглэлийг хүргүүлсэн. Тайлант хугацаанд 4 удаа зохион байгуулсан сургалтад 90 албан хаагч хамрагдаж 85 албан хаагч А-3 сертификаттай болсон.	100
12	Арга хэмжээ 1.12. Гадаад сургалт, олон улсын хурал болон туршлага солилцох уулзалтад албан	Буцалт гүй тус ламж	Гадаад сургалтын тоо; Олон улсын хурлын тоо; Олон улсын	12/3/6/67	4/2/1/30	Бүгд Найрамдах Энэтхэг Улсад англи хэлний мэдлэг дээшлүүлэх сургалтад 1, Швейцарийн холбооны улсын Женев хотноо олон улсын хуралд 1, Филиппин Улсын Манилла хотноо “Хувийн эрх зүйн Гаагийн чуулганы байнгын товчооноос Монгол Улсад 1993 оны Олон улсын	70

1	2	3	4	5	6	7	8
	хаагчдыг оролцуулах.		уулзалтын тоо; Хамрагдсан албан хаагчийн тоо			үрчлүүлэн авах тухай конвенцыг Азид үр дүнтэй хэрэгжүүлэх туршлага солилцох бүсийн семинар"-т 1, Бүгд Найрамдах Солонгос Улсын Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (КОЙКА)-аас Сөүл хотноо "Монгол Улсын Гадаадын иргэн, харьяатын газрын хүртээмжтэй үйлчилгээ, менежментийн чадавхыг бэхжүүлэх нь (2023-2025)" сэдэвт арга хэмжээнд 15, Унгар Улсын Будапешт хотноо "Гадаад иргэдийн бодлого зохицуулах ерөнхий газрын үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах" сургалтад 3, Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хотноо "Ховор ашигт малтмалын Олон Улсын форум 2025"-д 1 нийт 22 албан хаагчийг гадаад сургалт, арга хэмжээнд хамруулсан.	
13	Арга хэмжээ 1.13. Хилийн боомт орон нутагт ажилласан албан хаагчид олгох мөнгөн урамшууллыг зохих журмын дагуу шийдвэрлүүлэх, мэдээллийн санг шинэчлэх	Улсын төсөв	Шийдвэрлүүлсэн арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	100	100	Батлагдсан төсвийн хүрээнд хилийн боомтод ажилласан хугацааны мөнгөн урамшуулалд 2025 онд нийт 22 албан хаагчийн хамруулах судалгааг гарган Санхүү, хангалт үйлчилгээний газарт хүргүүлж, байгууллагын даргын 02 дугаар сарын 07-ны өдрийн Б/42 дугаар тушаалаар Агаарын замын боомт хариуцсан газрын 1 хяналтын улсын байцаагчид урамшуулал олгох тушаал батлуулсан. Гэвч энэ оноос Сангийн яамны "Төрийн албан хаагчдын цалингийн нэгдсэн систем"-д урамшууллын хуваарь, санхүүжилтийг холбосноос шалтгаалан хугацаа тоолох, урамшууллын мөнгөн дүнг тооцох журамд заасан зохицуулалт тухайн жилийн Төсвийн тухай хуультай зөрчилдөж байгааг Сангийн яамны төрийн нарийн бичгийн даргын 04 дүгээр сарын 04-ний өдрийн "Хариу өгөх тухай" албан бичгээр хууль тогтоомжид нийцүүлэх тухай чиглэл ирүүлсэн. Иймд байгууллагын даргын 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А/406 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Гадаадын иргэн, харьяатын газрын төрийн тусгай албан хаагчид хилийн боомт, орон нутагт ажилласан хугацааны мөнгөн урамшуулал олгох журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах, өөрчлөн найруулах санал боловсруулж, холбогдох нэгжүүдэд хүргүүлж, нэгтгээд байна.	30
14	Арга хэмжээ 1.14. Хилийн боомт, орон нутаг дахь нэгжид	Урсгал зардал	Томилсон албан хаагчийн тоо	-	7	Хилийн боомт, орон нутаг дахь нэгжид байгууллагын Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх албан хаагчийг томилох арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Ёс	100

1	2	3	4	5	6	7	8
	байгууллагын Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, мэдээлэл солилцох, уялдаа холбоо, зохицуулалтыг хангах, тайлагнах чиг үүрэг бүхий албан хаагчийг томилон ажиллуулах.					зүйн дэд хорооны 01 дүгээр сарын 27-ны өдрийн “Нэр ирүүлэх тухай” 01 дүгээр албан бичгийг орон нутаг дахь нэгжүүдэд хүргүүлж, ирүүлсэн саналыг хэлэлцэн байгууллагын даргын 02 дугаар сарын 25-ны өдрийн А/106 дугаар тушаалаар 7 нэгжид албан хаагч томилсон. Агаарын замын боомт хариуцсан газар болон Дорноговь аймаг дахь газрын томилогдсон албан хаагчдад мэдээлэл солилцох, уялдаа холбоо, зохицуулалтыг хэрхэн хангах талаар арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.	
15	Арга хэмжээ 1.15. Ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тодорхойлох судалгаа хийж, үр дүнд үндэслэн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохих арга хэмжээ авч хэрэгжүүлэх.	Урсгал зардал	Судалгааны тоо; Зохион байгуулалтын ажлын гүйцэтгэлийн хувь	-	1/100	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд 02 дугаар сарын 03-04-ний өдрийн хооронд зохион байгуулсан удирдах албан тушаалтны нэгдсэн цугларалтын үеэр тухайн нэгжийн хэмжээнд үүсэж болзошгүй ёс зүйн зөрчил, шалтгаан нөхцөлийг тодорхойлох зорилгоор хилийн боомт, орон нутаг дахь нэгжүүдийн нийт 22 албан хаагчийг санал асуулгад хамрууллаа. Мөн “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомж”-ийн талаар албан хаагчдын ёс зүйн тухай хууль тогтоомжийн мэдлэгийг шалгах, 03 дугаар сарын 21-ний өдөр төв байгууллагын 79, 03 дугаар сарын 31-ний өдөр Агаарын замын боомт хариуцсан газрын 25 нийт 104 албан хаагчийг хамруулсан.	90
16	Арга хэмжээ 1.16. Сахилга, ёс зүйн зөрчил давтан гаргасан албан хаагчдыг дахин зөрчил, дутагдал гаргахаас урьдчилан сэргийлэх зорилгоор улирал тутам арга хэмжээ авч хэрэгжүүлэх.	Урсгал зардал	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	-	4	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хүрээнд хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн албан хаагчдад сургалт зохион байгуулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороотой мэдээлэл солилцох, уялдаа холбоо, зохицуулалтыг хангах, тайлагнах чиг үүрэг бүхий холбогдох албан хаагчдыг арга зүйн зөвлөгөө, дэмжлэгээр хангах зорилгоор удирдамжийг боловсруулан, байгууллагын даргын 03 дугаар 11-ний өдрийн А/118 дугаар тушаалаар батлуулж, 03 дугаар сарын 31-ний өдөр Агаарын замын боомт хариуцсан газарт, 04 дүгээр сарын 08-10-ны өдрүүдэд Дорноговь аймаг дахь газарт ажиллаж Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан	100

1	2	3	4	5	6	7	8
						<p>хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилт, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, албаны чиг үүргээ хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлын талаар хамтарсан уулзалт зохион байгууллаа.</p> <p>Мөн Ёс зүйн дэд хорооны батлагдсан төлөвлөгөөний дагуу байгууллагын "Удирдах албан тушаалтны нэгдсэн цугларалт"-ын үеэр МУИС-ийн Олон улсын харилцааны тэнхимийн багш, профессор хамтран "Манлайлагчийн ёс зүй", Монголын Бурхан шашинтны төв Гандантэгчэнлин хийдийн Тэргүүн их хамба ламын ажлын албаны дарга, урьж, "Хувь хүний ёс суртахуун", Агаарын замын боомт хариуцсан газарт сэтгэл судлаач багшаар "Харилцаа, ёс зүй ба бидний хандлага", Дорноговь аймаг дахь газарт Удирдлагын академийн багш, доктор, дэд профессор багшаар "Төрийн үнэ цэнэ, төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг шаардлага" сэдэвт сургалтуудыг тус тус зохион байгууллаа. Сургалтад танхим болон цахимаар давхардсан тоогоор 234 албан хаагч хамрагдлаа.</p>	
17	<p>Арга хэмжээ 1.17. Жендерийн эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлан хэрэгжилтийг хангах</p>	Урсгал зардал	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	100	<p>Байгууллагын дэргэдэх Жендэрийн эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 02 дугаар сарын 24-ний өдөр байгууллагын даргаар батлуулж, 06 дугаар сарын 03-ны өдөр танилцуулсан.</p> <p>Хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрээнд: "Хөдөлмөрийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүмүүст тулгарч буй бэрхшээл ялгаатай байдлаас үүсэж буй эрэлт хэрэгцээ" сэдэвт сургалтыг 04 дүгээр сарын 01-ний өдөр зохион байгуулж, төв, орон нутгийн 154 албан хаагчийг хамруулсан.</p> <p>"Харилцан хүндэтгэе" аяны хүрээнд хэрэгжүүлсэн ажлын тайланг 04 дүгээр сарын 02-ны өдрийн 01/669, Жендэрийн үндэсний хороо, Хууль зүй, дотоод хэргийн яамны Жендэрийн салбар зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Жендэрийн үндэсний хорооны 2025 оны тогтоолын хэрэгжилт, Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах 2025 оны төлөвлөгөөний</p>	90

1	2	3	4	5	6	7	8
						<p>хэрэгжилт, албан хаагчдын хүйсийн тэнцвэрт байдлын мэдээг тус тус 05 дугаар сарын 21-ний өдрийн 01/992 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлсэн.</p> <p>Гэрлэлтийн гэрээний ач холбогдлын талаар судалж, Гэр бүлийн тухай хууль болон мэргэжлийн хуульчийн зөвлөгөө, мэдээллийг 04 дүгээр сарын 17-ны өдөр байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем, албан хаагчдын цахим группт тус тус байршуулж, төв, орон нутаг дахь нэгжийн 105 албан хаагчид танилцууллаа.</p> <p>Жендэрийн үндэсний хорооны "Иргэд олон нийтэд зориулсан жендэрийн цахим тест"-д төв байгууллагаас 53, орон нутаг дахь нэгжээс 90 нийт 143 албан хаагчийг хамрууллаа.</p> <p>Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх санал асуулгыг 05 дугаар сарын 07-12-ны өдрүүдэд төв, орон нутгийн 190 албан хаагчаас авч, дүнг 05 дугаар сарын 19-ний өдрийн 01-02/53 дугаар илтгэх хуудсаар байгууллагын даргад танилцуулсан.</p> <p>Дээрх судалгааны дүнг үндэслэн байгууллагын даргаас өгсөн чиглэлийн дагуу нарийвчлан тодруулах зорилгоор судалгааг 9 асуумжийн хүрээнд 05 дугаар сарын 22,23-ны өдрүүдэд дахин зохион байгуулж, төв, орон нутгийн 100 албан хаагчийг хамруулан дүнг 05 дугаар сарын 28-ны өдрийн 01-02/61 дүгээр илтгэх хуудсаар мөн байгууллагын даргад танилцуулсан</p>	
18	Арга хэмжээ 1.18. Жендэрийн тэгш байдлын талаар судалгаа хийж, үр дүнд үндэслэн зорилтот арга хэмжээ авч хэрэгжүүлэх.	Урсгал зардал	Судалгааны тоо; Зохион байгуулалтын ажлын гүйцэтгэлийн хувь	-	1/100	<p>Байгууллагаас гарч буй албан хаагчдад чиглэсэн бодлого, үйл ажиллагааны хэрэгжилт нь холбогдох хууль тогтоомжийн хүрээнд жендэрийн тэгш байдлыг хангасан эсэх, хүйсээс үл хамааран албан хаагчдад хүртээмжтэйгээр хүрсэн эсэх, ажил, албан тушаалд тухайн албан хаагчийг ажиллуулахдаа хүйсийн тэнцвэрт байдлыг хангах бодлого баримталсан эсэхэд харьцуулсан тэгш байдлын судалгааг 5 зорилтын хүрээнд 05 дугаар сарын 21-ний өдрөөс 06 дугаар сарын 02-ны өдрүүдэд хийж, судалгааны тайлан, санал, дүгнэлтийг 06 дугаар сарын 03-ны өдрийн 01-02/62 дугаар илтгэх хуудсаар байгууллагын даргад танилцууллаа.</p>	70
19	Арга хэмжээ 1.19.	Урсгал	Төлөвлөгөөний	100	100	Байгууллагын дэргэдэх "Эцэг,эхийн зөвлөл"-ийн 2025 оны	70

1	2	3	4	5	6	7	8
	Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр “Эцэг, эхийн зөвлөл”-ийн үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөө батлан хэрэгжилтийн хангах	зардал	хэрэгжилтийн хувь			<p>үйл ажиллагааны төлөвлөгөөг 04 дүгээр сарын 02-ны өдөр байгууллагын даргаар батлуулж, 06 дугаар сарын 04-ний өдөр танилцуулсан.</p> <p>Хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрээнд: Хүүхдийн төлөө дэд зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтийг 06 дугаар сарын 04-ний өдрийн 01/1089 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.</p> <p>Төв, орон нутгийн 0-16 хүртэлх насны хүүхэдтэй 212 албан хаагчийн 396 хүүхдийн дэлгэрэнгүй судалгааг гаргасан.</p> <p>Хүүхдийн мэргэжил сонголт, өсвөр насны хүүхдийн онцлог, анхаарах асуудал” сургалтыг 05 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулж, төв, орон нутгийн 119 албан хаагчийг, “Хөх тэнгис” сургалтын төвтэй хамтран 05 дугаар сарын 22-ны өдөр байгууллагын дэргэдэх “Эцэг, эхийн зөвлөл”-ийн гишүүдэд чадавжуулах сургалтыг цахимаар зохион байгуулж, 12 албан хаагчийг тус тус хамрууллаа.</p> <p>Байгууллагын 2024 оны А/454 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”-аар албан хаагчийн гэр бүлд шинээр хүүхэд мэндэлсэн, төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэд хүндээр өвдсөн, эсхүл сургууль, цэцэрлэгээс зохион байгуулах хурал бусад арга хэмжээнд оролцох тохиолдолд олговортой чөлөө, мөнгөн тусламж олгуулахаар зохицуулсан бөгөөд төв, хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн 12 албан хаагчид олговортой чөлөө болон мөнгөн тусламж үзүүллээ.</p>	
20	Арга хэмжээ 1.20. Албан хаагчдыг шагнуулах арга хэмжээг үе шаттай зохион байгуулах	Урсгал зардал	Төрийн дээд, салбарын, байгууллагын шагналаар шагнуулсан албан хаагчдын тоо	10/25/29	10/25/29	<p>Зохион байгуулалтын нэгжүүдээс төрийн дээд, салбарын шагналд 30 албан хаагчийг нэр дэвшүүлж ирүүлснээс шаардлага хангасан 26 албан хаагчийн саналыг 05 дугаар сарын 08-ны өдрийн 01-02/41 дүгээр илтгэх хуудсаар байгууллагын даргад танилцуулж, төрийн дээд, салбарын шагналд нэр дэвшүүлсэн 26 албан хаагчийн шагналын анкет, тодорхойлолт холбогдох баримтыг 05 дугаар сарын 28-ны өдрийн 01/1041 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд уламжилсан.</p> <p>Шагнал гардуулах үйл ажиллагааг Үндэсний их баяр наадмыг тохиолдуулан зохион байгуулахаар төлөвлөж байна.</p>	50

1	2	3	4	5	6	7	8
21	Арга хэмжээ 1.21. Албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах	Урсгал зардал	Хамрагдсан албан хаагчийн тоо	33	100	Албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, бусад нарийн мэргэшлийн оношилгоо шинжилгээнд хамруулахаар санал хүсэлтийг 04 дүгээр сарын 28,29-ний өдрүүдэд авч, хамрагдах шинжилгээг төрөлжүүлэн, Улсын төв Нэгдүгээр эмнэлэгт урьдчилан сэргийлэх үзлэг, бусад үзлэг шинжилгээг зохион байгуулах саналыг 05 дугаар сарын 12-ны өдрийн 02/925 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Төв байгууллагаас “Сити фарм дэнк” ХХК-тай хамтран байгууллагын спорт зааланд 05 дугаар сарын 13,14-ний өдрүүдэд 98 албан хаагчийг эрдсийн шинжилгээнд хамруулж, мэргэжлийн эмчийн зөвлөгөө, дүгнэлт өгсөн.	90
22	Арга хэмжээ 1.22. Хууль сахиулах ажиллагаанд хүний эрх, жендэрийн тэгш байдлыг дээшлүүлэх чиглэлээр “Жендэрийн олон улсын хөтөлбөр”-т гишүүнээр оролцох бэлтгэл ажлыг хангах.	Урсгал зардал	Зохион байгуулалтын ажлын гүйцэтгэлийн хувь	-	100	Хууль сахиулах ажиллагаанд хүний эрх, жендэрийн тэгш байдлыг дээшлүүлэх чиглэлээр “Жендэрийн олон улсын хөтөлбөр”-т оролцох хүсэлтийг 01 дүгээр сарын 03-ны өдөр НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөрийн төслийн үндэсний зохицуулагч цахимаар хүргүүлсэн боловч 02 дугаар сарын 28-ны өдрөөс хойш НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилтийг зогсоож цаашид уг төсөл хөтөлбөр хэрэгжихгүй болсон талаар төслийн үндэсний зохицуулагч хариу өгсөн.	100
Зорилт 2. Байгууллагаас гаргаж буй эрх зүйн баримт бичиг, гэрээ, хэлэлцээр болон бусад эрхийн баримт бичиг, тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянах, байгууллагын дотоод хяналт, аюулгүй байдлыг хангах, хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулалтын удирдлагаар хангах							
23	Арга хэмжээ 2.1. Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэх	Урсгал зардал	Хүргүүлсэн саналын тоо	-	1	Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал, танилцуулга боловсруулж, 01 дүгээр сарын 08-ны өдрийн 01/38 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлсэн.	100
24	Арга хэмжээ 2.2. Хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах	Урсгал зардал	Тайлан бэлтгэж, хүргүүлсэн гүйцэтгэлийн хувь	100	100	Монгол Улсын хууль тогтоомжийн 2024 он, 2025 оны 01 дүгээр сарын тайланг цахимаар, 1 дүгээр улирлын тайланг 01/679 дүгээр албан бичгээр тус тус хугацаанд нь ХЗДХЯ-д хүргүүлсэн. “Алсын хараа-2050” МУУХХБ-ын 2024 оны тайланг цахимаар, тус бодлогын баримт бичигт үнэлгээ хийж	90

1	2	3	4	5	6	7	8
	ажлыг зохион байгуулах					<p>байгаатай холбогдуулан үр дүнгийн тайланг 01/773, Монгол Улсыг 2020-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2024 оны тайланг 01/2563, хоёр удаагийн нотломж, нэмэлт мэдээллийг тухай бүр, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн тайланг цахимаар, 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан зорилтын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг 01/200, Хууль тогтоомж, Бодлогын баримт бичгийн 2025 оны 1 дүгээр улирлын тайланг 01/679 дүгээр албан бичгээр ХЗДХЯ-д тус тус хүргүүлсэн.</p> <p>Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 71 дүгээр захирамж, 2024 оны 01, 02, 03 дугаар, 2025 оны 02 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг цахим шуудан болон 2024 оны 02/2446, 02/2710 дугаар, 2025 оны 01/622 дугаар албан бичгээр ХЗДХЯ-д тус тус хүргүүлээ.</p> <p>ЗГХЭГ-аас яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлаг, Шадар сайдын ажлын албанд хүргүүлсэн чиглэлийн дагуу авсан арга хэмжээний биелэлтийг 01/2476, Монгол Улсад хувийн хэргээр оршин суух гадаадын иргэдийн 2020-2024 оны тоон мэдээ, цагаачлан оршин суух гадаадын иргэдийн 2022-2024 оны тоон мэдээг 01/104, “Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг хамгаалах, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний 2023, 2024 оны хэрэгжилтийг 01/302 дугаар албан бичгээр тус тус ХЗДХЯ-д хүргүүлэв.</p> <p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2024 оны 73 дугаар зарлигийн дагуу 2024 оны 4 дүгээр улирал, 2025 оны 1 дүгээр улирлын танилцуулах мэдээг 01/2496, 01/631 дүгээр албан бичгээр тус тус ХЗДХЯ-д хүргүүлээ.</p> <p>“НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2023-2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг 01/2547 дугаар албан бичгээр ГХЯ-д хүргүүлсэн.</p>	
25	Арга хэмжээ 2.3. Хууль зүй, дотоод хэргийн сайдын шуурхай хурлаас гарсан үүрэг	Урсгал зардал	Биелэлт бэлтгэж, хүргүүлсэн гүйцэтгэлийн хувь	100	100	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн шуурхай хуралдаанаар өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 01 дүгээр сарын 07-ны өдөр байгууллагын даргаар батлуулж, ер.e-mongolia.mn системээр нийт албан хаагчдад танилцуулан	90

1	2	3	4	5	6	7	8
	даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, гүйцэтгэлийг тайлагнах					<p>биелэлтийг хангуулж, тайланг 02 дугаар сарын 20-ны өдөр удирдлагад танилцууллаа.</p> <p>Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн шуурхай хуралдаанаар өгсөн үүрэг даалгаврын хүрээнд төрийн албан хаагчид болон олон нийтэд хууль тогтоомж сурталчлах ажлын 2025 оны төлөвлөгөөнд саналыг 01 дүгээр сарын 07-ны өдрийн 02/34 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.</p> <p>Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг 04 дүгээр сарын 07-ны өдрийн 01/700 дугаар албан бичгээр болон цахим хаягаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүллээ.</p> <p>Тайлант хугацаанд сайдын шуурхай хуралдаан дахин хуралдаагүй болно.</p>	
26	Арга хэмжээ 2.4. "Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө"-ний төсөлд санал хүргүүлэх	Урсгал зардал	Төсөлд санал хүргүүлсэн огноо, дугаар	1	1	<p>"Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө"-ний төсөл боловсруулах ажлын хэсгийг байгууллагын даргын 2024 оны А/524 дүгээр тушаалаар байгуулсан. Ажлын хэсэгт нарийн бичгийн даргаар ажиллаж, нэгжүүдээс саналыг нэгтгэн Эдийн засаг, хөгжлийн сайдын 2022 оны А/167 дугаар тушаалаар батлагдсан "Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал"-ын дагуу боловсруулж, 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01/70 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн сайд хүргүүлсэн.</p> <p>"Монгол Улсын хөгжлийн 2026 оны баримтлах бодлого, тэргүүлэх чиглэл"-ийн төсөлд саналыг боловсруулан 03 дугаар сарын 11, 17-ны өдөр, "Монгол Улсын хөгжлийн 2026 оны баримтлах бодлого, тэргүүлэх чиглэл" болон "Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө"-ний Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Эдийн засаг, хөгжлийн яамнаас эцэслэсэн төсөлд саналыг 04 дүгээр сарын 17-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яаманд цахимаар хаягт тус тус хүргүүлсэн.</p>	100
27	Арга хэмжээ 2.5. Байгууллагын үйл	Урсгал зардал	Байгууллагын цахим хуудас,	155/175/467	150/120/300	Тайлант хугацаанд үйл ажиллагаатай холбоотой 39 мэдээ бэлтгэж, байгууллагын сайтад нийт 79 мэдээ, ярилцлага,	100

1	2	3	4	5	6	7	8
	ажиллагаа, эрхлэх чиг үүрэгтэй холбоотой мэдээ, мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлэх		олон нийтийн цахим сүлжээнд байршуулсан мэдээллийн тоо			<p>видео, нээлттэй мэдээллийг байршуулан олон нийтэд ил тод мэдээллээ.</p> <p>Бэлтгэсэн мэдээллийг давхардсан тоогоор 379 хэвлэл мэдээллийн хэрэгслээр (334 сайт, 14 сонин, 22 телевиз) сурталчилсан. Тухайлбал, "Виз, визийн зөвшөөрөл олголт 98.4 хувьтай байна" гарчигтай мэдээг 13 сайт, 2 телевизээр, "гадаадын 653,545 иргэнд цахимаар үйлчилгээ үзүүлээ" мэдээг 11 сайт, 1 телевиз, 2 сонинд, "Өнгөрөгч онд 25 улсын 998 гадаадын иргэнийг албадан гаргалаа" гарчигтай мэдээг 24 сайт, 3 телевизээр, "Гадаадын иргэний оршин суух үнэмлэхийг киоск машинаас хэвлэж авах боломжтой боллоо" мэдээг 19 сайт, 2 телевиз, 2 сонинд, "2024 онд 30 улсын 2084 иргэнийг хил нэвтрүүлэлгүй буцаажээ" гарчигтай мэдээг 14 сайт, 2 телевизээр, "81 аж ахуйн нэгж, байгууллага, 1786 гадаадын иргэнийг хяналт шалгалтад хамрууллаа" мэдээг 39 сайт, 2 телевиз, 2 сонинд, "Интерполоор эрэн сурвалжлагдаж байсан БНСУ-ын иргэнийг хяналт шалгалтаар илрүүлээ" мэдээг 25 сайт, 2 телевиз, 2 сонинд тус тус нийтлүүлж, олон нийтэд мэдээлсэн.</p> <p>2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр байгууллагын дарга Н.Ууганбаяр tsahiur.mn сайтад цахим виз олголт, 2025 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр tv5 телевизэд хил дээрээс буцаагдсан гадаадын иргэдтэй холбоотой асуудлаар ярилцлага, тодруулга өгөв.</p>	
28	Арга хэмжээ 2.6. Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээ, хууль тогтоомжтой холбоотой мэдээ, мэдээллийг олон нийтийн цахим сүлжээнд түгээх ажлыг зохион байгуулах	Урсгал зардал	Түгээсэн мэдээллийн тоо; Түгээсэн цахим группийн тоо	-	120/80	<p>Тайлант хугацаанд нийгмийн сүлжээ дэх байгууллагын цахим хуудаст үйл ажиллагаа, үйлчилгээ, хууль тогтоомжийг сурталчилсан нийт 110 мэдээлэл байршуулсан. Дээрх мэдээ, мэдээллийг "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 8.4.11-д заасны дагуу нийт албан хаагчид давхардсан тоогоор 21230 түгээлт хийсэн байна. Тухайлбал, 2024 оны 12 дугаар сард 15 мэдээллийг 3478, 01 дүгээр сард 13 мэдээллийг 3507, 02 дугаар сард 20 мэдээллийг 4405, 03 дугаар сард 16 мэдээллийг 2989, 04 дүгээр сард 18 мэдээллийг 3009, 05 дугаар сард 21 мэдээллийг 3131, 06 дугаар сард 7 мэдээллийг 711 түгээсэн байна.</p> <p>Мэдээллийн дундаж түгээлт 193 байна. Цахим хуудаст тогтмол мэдээлэл байршуулж, түгээлт хийснээр</p>	50

1	2	3	4	5	6	7	8
						байгууллагын цахим хуудас 26,663 дагагчтай, дундаж хандалт 135,763 болж өссөн.	
29	Арга хэмжээ 2.7. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлан хэрэгжилтийг хангах.	Урсгал зардал	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	50	100	<p>Байгууллагын Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөг 01 дүгээр сарын 20-ны өдөр байгууллагын даргаар батлуулан зохион байгуулалтын нэгжүүдэд хүргүүлж, төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системд байршуулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.</p> <p>Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс зохион байгуулсан “Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх”, Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газраас зохион байгуулсан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт” сэдэвт сургалтад албан хаагчдыг тус тус хамруулсан.</p> <p>2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 01-02/26 дугаар “Хяналтын улсын байцаагчийг чадавхжуулах сургалтын удирдамж”-ын хүрээнд Эрүүдэн шүүх конвенцын талаарх ойлголт сэдвээр хяналтын улсын 9 байцаагчид сургалт орсон. Дорноговь аймаг дахь газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 12/04 дүгээр “Авлига ашиг, сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” сургалт зохион байгуулах удирдамжийг батлуулан 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр Авлигатай тэмцэх газрын урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан Б.Болд “Авлигын ойлголт, түүний хор уршиг” сэдвээр 1 цагийн сургалт зохион байгууллаа. Сургалтад танхимаар 10, цахимаар 13 нийт 23 албан хаагч хамрагдаж авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгууллаа.</p> <p>Төвийн албан хаагчид болон орон нутаг дахь нэгжийн дарга нар зэрэг нийт 24 албан хаагчаас гадаад улсад албан болон хувийн зорилгоор зорчсон тохиолдолд “гадаад улсад зорчих албан хаагчийн баталгаа”-г гаргуулан авч, бүртгэл хөтлөн хяналт тавьж байна.</p>	90
30	Арга хэмжээ 2.8. Гамшгаас хамгаалах	Урсгал зардал	Хууль тогтоомжийн	90	100	Байгууллагын даргын 2024 оны 12 сарын 30-ны өдрийн “Гамшгаас хамгаалах орон тооны бус штаб, бүлэг	90

1	2	3	4	5	6	7	8
	хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах		хэрэгжилтийн хувь			байгуулах тухай” А/594 дүгээр тушаалаар бүлгийг шинэчлэн байгуулж холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Гамшгаас хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Хан-Уул дүүргийн Засаг даргаас 03 дугаар сарын 25-ны өдрийн 84 дүгээр албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу 03 дугаар сарын 27-ны өдрийн 16:00 цагт албан хаагчдын бэлэн байдлыг хангуулж, төв байрны 80 албан хаагчийг цуглах цэгт жагсаан үр дүнг мөн өдрийн 02/21 дүгээр албан бичгээр тус дүүргийн 21 дүгээр хорооны Засаг даргад хүргүүлсэн. Байгууллагын даргын 2025 оны 01-02/27 удирдамжийн дагуу Гамшгаас хамгаалах сургалтын төв 116 дугаар ангитай хамтран 05 дугаар сарын 14-ны өдөр “Гамшиг эрсдэлийн үед авах арга хэмжээ” сэдэвт сургалтыг зохион байгуулж, сургалтад төвийн нэгжийн 15 албан хаагч хамрагдсан. 2025 оны 05 дугаар сарын 20-ний өдрийн 2/89 дугаартай Монгол цэргийн холбооноос ирүүлсэн албан бичгийн дагуу 05 дугаар сарын 23-ний өдөр Монгол цэргийн холбоонд зохион байгуулагдсан “Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх, орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бэхжүүлэхэд оролцогч байгууллагуудын бодлого, зохицуулалт, үйл ажиллагааны өнөөгийн байдалд дүгнэлт хийх” сэдэвт хурал, зөвлөгөөнд дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн Г.Түмэндэлгэр хамрагдсан.	
31	Арга хэмжээ 2.9. Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах	Урсгал зардал	Гүйцэтгэлийн хувь	100	100	Гадаадын иргэн, харьяатын газрын үйл ажиллагаанд 2025 онд хийх дотоод аудит, дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөг 01 дүгээр сарын 09-ний өдөр байгууллагын даргаар батлуулсан. 2025 оны хагас жилийн байдлаар хууль тогтоомжийн хүрээнд байгууллагын даргын баталсан удирдамжийн дагуу 11 албан хаагчид холбогдуулан 8 төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг явуулснаас Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.1-д заасан “өөрт ганцаарчилсан хэлбэрээр сануулах” сахилгын шийтгэл 3 албан хаагчид, 48.1.3-д заасан “албан тушаалын цалингийн хэмжээг 3 сар хүртэл хугацаагаар 20 хувиар бууруулах” сахилгын шийтгэл 2 албан хаагчид тус тус ногдуулсан. 3 албан хаагчийн ёс зүйн хариуцлагын талон цоолсон.	90

1	2	3	4	5	6	7	8
32	Арга хэмжээ 2.10. Эрх олгосон албан хаагчид тэмдэг түших, хүчингүй болгох, хураан авах, бүртгэл хөтлөх ажлыг зохион байгуулах	Урсгал зардал	Гүйцэтгэлийн хувь	100	100	Байгууллагын даргын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн Б/02 дугаар тушаалаар 1, Б/09 дүгээр тушаалаар 1, 03 дугаар сарын 06-ны өдрийн Б/48 дугаар тушаалаар 1, 03 дугаар сарын 07-ны өдрийн Б/53 дугаар тушаалаар 1, 03 дугаар сарын 31-ний өдрийн Б/72 дугаар тушаалаар 1, Б/73 дугаар тушаалаар 1, Б/74 дүгээр тушаалаар 1, 04 дүгээр сарын 01-ний өдрийн Б/78 дугаар тушаалаар 1, 04 дүгээр сарын 10-ны өдрийн Б/82 дугаар тушаалаар 1, Б/83 дугаар тушаалаар 5, 05 дугаар сарын 15-ны өдрийн Б/108 дугаар тушаалаар 1, Б/110 дугаар тушаалаар 1, 05 дугаар сарын 20-ний өдрийн Б/113 дугаар тушаалаар 1, Б/114 дүгээр тушаалаар 1, Б/115 дугаар тушаалаар 1, Б/117 дугаар тушаалаар 1 нийт 20 албан хаагчид “хяналтын улсын байцаагч” болон “Бүртгэсэн, хүртэл” тэмдгийг түшүүлэх арга хэмжээг зохион байгуулсан.	90
33	Арга хэмжээ 2.11. Даргын дэргэдэх зөвлөл, Мэргэжлийн зөвлөлийн хурлыг зохион байгуулах	Урсгал зардал	Хурал зохион байгуулалтын хувь	90	100	Даргын дэргэдэх зөвлөлийн 02 дугаар сарын 26-ны өдөр, 05 дугаар сарын 02, 26-ны өдрийн нийт 3 удаагийн хурал болон Мэргэжлийн зөвлөлийн 01 дүгээр сарын 03, 24, 27-ны өдөр, 03 дугаар сарын 13-ны өдөр, 04 дүгээр сарын 07, 09-ний өдөр, 05 дугаар сарын 02 өдрүүдэд нийт 7 удаагийн хурлыг зохион байгуулж, тэмдэглэл хөтлөн баталгаажуулсан. Түүнчлэн удирдлагын шуурхай хуралдааныг 01 дүгээр сарын 02, 09, 30-ны өдөр, 03 дугаар сарын 11-ний өдрүүдэд тус тус зохион байгуулж, тэмдэглэл хөтлөн баталгаажуулж ажиллалаа.	90
34	Арга хэмжээ 2.12. Төрийн болон албаны нууцын албан хэрэг хөтлөлтийг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулах	Урсгал зардал	Гүйцэтгэлийг хангаж ажилласан хувь	100	100	Төрийн болон албаны нууцын албан хэрэг хөтлөлтийг Төрийн болон албаны нууцын тухай хууль, Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам”, Байгууллагын даргын 2022 оны А/131 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон албаны нууц хамгаалах журам”-ын дагуу эрхлэн зохион байгуулж байна. Тайлант хугацаанд нууцын зэрэглэлтэй ирсэн 13 албан бичгийг хүлээн авч, эрх бүхий албан тушаалтнуудад биечлэн танилцуулсан. Нууцын зэрэглэлтэй явуулсан 17 албан бичгийг холбогдох байгууллагад биечлэн хүргэж ажиллав.	90

1	2	3	4	5	6	7	8
Зорилт 3. Байгууллагын төв болон хилийн боомт, орон нутаг дахь газар, хэлтсийн үйл ажиллагааны харилцан уялдааг хангаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, нэгжийн үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх, төлөвлөх, тайлагнах							
35	Арга хэмжээ 3.1. Монгол Улсын хууль тогтоомжид санал хүргүүлэх, байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагаанд хамаарах эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгох	Урсгал зардал	Санал хүргүүлсэн хууль тогтоомж; Боловсруулж баталсан эрх зүйн баримт бичгийн тоо	7/6	5/5	Хуулийн төсөлд 2 удаа санал хүргүүлсэн. Үүнд: Худалдан авах ажиллагааны тухай хуулийн төсөл, Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд тус тус санал хүргүүлсэн бөгөөд Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл нь 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр lawforum.parliament.mn цахим хуудасны “боловсруулж буй төслүүд” цэсэд байршсан байна. Мөн Засгийн газрын тогтоолын төсөлд 2, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын төсөлд 1, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирүүлсэн журмын төсөлд 1 удаа буюу дээд шатны байгууллагаас ирүүлсэн журмын төсөлд нийт 4 удаа санал боловсруулан хүргүүлсэн. Байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр 254, хүний нөөцийн чиглэлээр 122 нийт 376 тушаалын төсөл, бусдаар гүйцэтгүүлэх ажлын хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж гэрээ хийгдсэн 9, хамтран ажиллах, үйлчилгээ үзүүлэх, нэмэлт зэрэг бусад гэрээ 6, нийт 15 гэрээний төслийг тус тус хууль тогтоомжид нийцүүлэн хянаж, бүртгэснээр байгууллагын дарга баталгаажуулсан. Тайлант хугацаанд хянагдаж байгаа гэрээний төсөл 3 байна.	100
36	Арга хэмжээ 3.2. Хууль тогтоомжийн сан бүрдүүлэх ажлыг зохион байгуулах	Урсгал зардал	Журмын нэгдсэн бүртгэл хөтөлсөн хувь	90	100	Байгууллагын даргын 2025 оны А/168 тушаалаар “Кибер аюулгүй байдлын хангах журам”, А/226 тушаалаар “Хяналтын улсын байцаагчийн ажиллах заавар”-ыг тус тус шинэчлэн баталж, А/231 тушаалаар “Ёс зүй зөвлөлийн ажиллах журам”-ыг хүчингүй болгож, А252 тушаалаар Дотоод хяналт шалгалтын журамд нэмэлт, өөрчлөлт тус тус оруулсанг бүртгэж, тайлант хугацаанд өөрчлөлтийн бүртгэлийг бүрэн хөтөлсөн. Мөн Гадаадын иргэн, харьяатын газрын цахим хаягийн https://immigration.gov.mn/mn/legal/ эрх зүйн мэдээллийн хэсгээр иргэд үйлчлүүлэх, ашиглах боломжийг бүрдүүлсэн. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийг англи, орос, солонгос, хятад, япон 5 хэл дээр, уг хуулийг дагалдан гарсан “Монгол Улсын виз олгох журам”, “Гадаадын	90

1	2	3	4	5	6	7	8
						<p>иргэнийг Монгол Улсаас албадан гаргах, албадан гаргахгаас чөлөөлөх болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журам”, “Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам”-ыг тус тус хятад, солонгос хэлнээ хөрвүүлэн цахим хуудасны “Хууль эрх зүй” цэсэд байршуулж, гадаадын иргэний үйлчилгээ авах эрхийг хангаж байна.</p> <p>Одоогоор байгууллагын хуулийн сан https://legal-efwpp.app.mcloud.gov.mn/ цахим хаягт Эрх зүйн актын лавлагаа 5, Засгийн газрын тогтоол 15, Төрийн мэдээлэл 68, Иргэд визгүй зорчих орны лавлагаа 77, Сайдын тушаал 27, Хууль бусаар байгаа иргэдийг буцаан шилжүүлэх тухай хэлэлцээр 1, Монгол Улсын нэгдсэн орсон олон талт гэрээ 7, Төрийн бусад байгууллага 3, Албан даалгавар 7, Хилийн боомтын дэглэмийн тухай гэрээ 4, ГИХГ-ын даргын баталсан журам нийтээр дагаж мөрдөх 4, дотогш чиглэсэн 76, хамтран ажиллах 20, Мэдээлэл засварлах маягт 2, Хууль 28, Хичээл гарын авлага 2 нийт 18 төрлийн дэд системд 444 хууль, журам, гэрээ, бусад зохицуулалтын шинжтэй эрх зүйн баримт бичгүүдийг бүртгэж, баяжилт, хөгжүүлэлтийг тухай бүр хийж байна.</p>	
37	Арга хэмжээ 3.3. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангах	Урсгал зардал	Тайлангийн тоо	2	2	<p>Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах саналыг зохион байгуулалтын нэгжүүдээс ирүүлснийг нэгтгэн боловсруулж, 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн Даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Төлөвлөгөөний төслийг 12 дугаар сарын 27-ны өдрийн 01/2600 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, яамнаас өгсөн чиглэлийн дагуу холбогдох нэмэлт, өөрчлөлтийг тусгасан. Төлөвлөгөөг хууль зүй, дотоод хэргийн сайд 01 дүгээр сарын 05-ны өдөр хянан баталгаажуулсныг хүлээн авч, төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системээр нийт албан хаагчдад танилцууллаа.</p> <p>Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө батлагдсантай холбогдуулан 16 зохион байгуулалтын нэгжийн төлөвлөгөөг хүлээн авч, удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу холбогдох нэмэлт, өөрчлөлтийг хийлгэн 01 дүгээр сарын 07-ны өдөр байгууллагын даргаар батлуулж, нэгж бүрд хүлээлгэн өгөв.</p>	90

1	2	3	4	5	6	7	8
						<p>Байгууллагын даргын 2024 оны А/455 дугаар тушаалаар баталсан “Байгууллагын үйл ажиллагааг төлөвлөх, тайлагнахад баримтлах заавар”-ын дагуу 06 дугаар 12-ны өдрийн дотор зохион байгуулалтын нэгжүүдээс хүлээн авч, 13-ны өдөр ХШҮАХ-т хүргүүлнэ.</p> <p>Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай танилцуулга, анхаарах асуудлыг тусгасан Захиргаа, удирдлагын газрын даргын 05 дугаар сарын 23-ны өдрийн 02/69 дүгээр дотоод албан бичиг боловсруулж, ERP системд нийтэлж нийт албан хаагчдад танилцууллаа.</p>	
38	<p>Арга хэмжээ 3.4. Байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөний төслийг боловсруулж, батлуулах</p>	Урсгал зардал	Стратеги төлөвлөгөө батлуулсан огноо	-	1	<p>Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 2025-2028 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөнд тусгах санал болон байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөний төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгууллагын даргын 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/542 дугаар тушаалаар байгуулсан.</p> <p>Ажлын хэсгийн хурлыг 12 дугаар сарын 06, 12, 13-ны өдрүүдэд 3 удаа зохион байгуулж, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтсээс ирүүлсэн холбогдох шинжилгээ болон зохион байгуулалтын нэгжүүдээс ирүүлсэн саналыг тус тус хэлэлцэв.</p> <p>Төлөвлөгөөнд 5 зорилгын хүрээнд 18 арга хэмжээ тусган ажлын хэсгийн хурлаар төлөвлөгөөний төслийг хэлэлцэж, эцэслэснийг 12 дугаар сарын 13-ны өдөр удирдлагын багт танилцуулж баталгаажуулав. Салбарын болон байгууллагын стратеги төлөвлөгөөний төслийг ажлын хэсгийн тушаалын хамт 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 01/2489 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яамны төрийн нарийн бичгийн даргад хүргүүлсэн. Түүнчлэн яамнаас ирүүлсэн чиглэлийн дагуу байгууллагын стратеги төлөвлөгөөг шинэ маягтын дагуу боловсруулж, 01 дүгээр сарын 03-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яаманд цахим хаягаар хүргүүлээ.</p> <p>ХЗДХЯ-ны ТЗУГ-аас 04 дүгээр сарын 03-ны өдөр ирүүлсэн байгууллагын стратеги төлөвлөгөөний төслийг шинэ загвараар боловсруулан хүргүүлэх яаралтай чиглэлийн</p>	90

1	2	3	4	5	6	7	8
						дагуу дахин боловсруулж, ХЗДХЯ-ны ТЗУГ-т цахимаар) хүргүүлээ.	
39	Арга хэмжээ 3.5. Байгууллагын үйл ажиллагааны сар бүрийн төлөвлөгөө батлуулах	Урсгал зардал	Төлөвлөгөө батлуулсан огноо	12	12	Байгууллагын даргын А/455 дугаар тушаалаар баталсан "Байгууллагын үйл ажиллагааг төлөвлөх, тайлагнахад баримтлах заавар"-ын дагуу байгууллагын үйл ажиллагааны 01-06 дугаар сарын төлөвлөгөөнд тусгах саналыг зохион байгуулалтын нэгжүүдээс хүлээн авч, нэгтгэн тухай бүр Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системээр албан хаагчдад мэдээлсэн.	100
40	Арга хэмжээ 3.6. Байгууллагын үйл ажиллагааны сарын тайлан гаргах	Урсгал зардал	Тайлангийн тоо	12	12	Байгууллагын үйл ажиллагааны 2024 оны 12 дугаар сар, 2025 оны 01-05 дугаар сарын төлөвлөгөөний хэрэгжилтийг нэгтгэн, тайлан боловсруулж, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэст дотоод журамд заасан хугацаанд тухай бүр хүргүүлж, үнэлгээ хийлгэсэн. Гүйцэтгэл 93.9, 95.1, 92.2, 86.1, 95.1, 97.7 хувьтай тус тус дүгнэгдсэн.	100
Зорилт 4. Нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх							
41	Арга хэмжээ 4.1. Боомт, орон нутаг дахь нэгжийн сарын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг хүлээн авч, цахим санд хадгалах	Урсгал зардал	Хүлээн авсан төлөвлөгөөний тоо; Хүлээн авсан тайлангийн тоо.	12	12	Хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн нөхцөл байдал, гадаадын иргэний хөдөлгөөний мэдээг өдөр тутам удирдлагад танилцуулж, сар, улирлын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан болон боомтод ажиллах албан хаагчдын улирлын хуваарийг тогтоосон хугацаанд тухай бүр танилцуулан хяналт тавьж байна. Хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн 01-06 дугаар сарын төлөвлөгөө, 01-05 дугаар сарын үйл ажиллагааны сарын тайланг хүлээн авч, төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системд үүсгэсэн цахим санд сар бүр хадгалсан.	100
42	Арга хэмжээ 4.2. Боомт, орон нутаг дахь нэгжид цаг үеийн холбогдолтой мэдээ, мэдээлэл, чиглэл хүргүүлэх	Урсгал зардал	Мэдээ, мэдээлэл, чиглэл хүргүүлсэн эсэх	90	100	Хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн албан хаагчдыг ISF системд ажиллуулах, дадлагажуулах хүрээнд албан тушаалтны нэрсийг хүснэгтийн дагуу ирүүлэх дотоод албан бичиг хүргүүлж, виз, зөвшөөрлийн газарт холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн. "Монгол Улсад аялал жуулчлалын зорилгоор ирэх БНСУ-ын иргэдийг 90 хүртэл хоногийн хугацаанд визгүй зорчуулах шийдвэрийг 2025 оныг дуустал сунгасан тухай Засгийн газрын 235 дугаар тогтоол, Иргэний нисэхийн	100

1	2	3	4	5	6	7	8
						<p>үндэсний төвөөс ирүүлсэн албан байгууллагын нэр өөрчлөгдсөн тухай албан бичиг, БНСВУ-ын иргэдийг хилээр орж, гарахад баримт бичигт штамп дарахгүй болсон талаар мэдэгдсэн албан бичиг, "Дипломат, албан, тусгай болон сервис паспорт эзэмшигчдийг визийн шаардлагаас харилцан чөлөөлөх тухай Монгол улсын Засгийн газар болон Оманы султант улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг хилийн боомт, орон нутаг дахь нэгжүүдэд тус тус танилцуулж, чиглэл хүргүүлсэн.</p> <p>Мөн Боомтын үндэсний хорооноос 05 дугаар сарын 06-ны өдрийн 02/641 дүгээр албан бичгээр ирүүлсэн хилийн Цагаандэл-Уул боомтын нээн ажиллуулах, бэлтгэл ажлыг хангуулах тухай албан бичгийг Өмнөд бүс дэх газарт хүргүүлж, чиглэл өгсөн.</p> <p>Хилийн боомт, орон нутаг дахь газруудаас сар бүр гадаадын иргэдийн бүртгэл, хяналтын мэдээллийг авах хүснэгтийг хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудит болон мэдээлэл технологийн хэлтэстэй хамтран боловсруулсан.</p> <p>Мөн хилийн боомт, орон нутаг дахь нэгж, хэлтсийн дарга болон хяналтын улсын байцаагч нартай виз зөвшөөрлийн шалгах материалын талаар 04 дүгээр сарны 22-ны өдөр цахим хурал зохион байгуулж, хурлын тэмдэгллийг удирдлагад танилцуулсан.</p>	
43	Арга хэмжээ 4.3. Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэх	Урсгал зардал	Шийдвэрлэлтийн хувь	96.8	100	<p>Тайлант хугацаанд байгууллагын төвд 375 (иргэнээс 279 өргөдөл, 1 талархал, 30 гомдол, албан хаагчдаас 65 өргөдөл), боомт, орон нутаг дахь нэгжүүдэд 87 (иргэнээс 17 өргөдөл, 1 гомдол, албан хаагчдаас 69 өргөдөл), нийт 462 өргөдлийг хүлээн авч, өмнөх сарын үлдэгдэл 32, нийт 463 өргөдлийг шийдвэрлэсэн байна.</p> <p>Нийт өргөдөл, гомдлын шийдвэрлэлт өссөн дүнгээр 93.7 хувьтай, 31 өргөдөл хяналтад буюу шийдвэрлэх шатанд байна.</p> <p>Үүнээс Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөс манай байгууллагад 1 талархал, 3 хүсэлт, 23 гомдол шилжүүлснийг хүлээн авч, шийдвэрлэсэн байна.</p>	90
44	Арга хэмжээ 4.4. Байгууллагын даргын баталсан тушаал шийдвэрийн	Урсгал зардал	Хэрэгжилтийг хангаж ажилласан хувь	90	100	<p>Тайлант хугацаанд хүний нөөцийн чиглэлээр Б тушаал 122, байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр гарсан А тушаал 254, үүнээс зөрчил шалган шийдвэрлэх чиглэлээр 179, оршин суух зөвшөөрлийн чиглэлээр 20, бусад чиглэлээр 55</p>	90

1	2	3	4	5	6	7	8
	хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих					нийт 376 тушаалыг бүртгэж, хяналт тавин ажиллалаа.	
45	Арга хэмжээ 4.5. 2023 оны түр хадгалах хөрөнгө оруулагчийн баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх	Урсгал зардал	Цахим хэлбэрт шилжүүлсэн хувь	-	100	Хугацаа болоогүй	
46	Арга хэмжээ 4.6. 2012 оны байнга хадгалах баримтыг Үндэсний төв архивд шилжүүлж хөмрөгийн бүрдүүлэлт хийх	Урсгал зардал	Гүйцэтгэлийн хувь	100	100	2012 оны байнга хадгалах баримтын хуудсыг засварлаж (ар талын бичвэртэй хуудсыг дахин дугаарласан) Үндэсний төв архивд шилжүүлэхэд бэлэн болгосон ба 09 дүгээр сард шилжүүлэхээр тохиролцсон.	90
47	Арга хэмжээ 4.7. Байгууллагын 2024 оны архивыг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэх	Урсгал зардал	Зохион байгуулалтын ажлын гүйцэтгэлийн хувь	100	100	Байгууллагын архивд баримт хүлээн авах хуваарийг нэгжийн даргаар батлуулж, төвийн 9 нэгжээс нийт 731 ширхэг хадгаламжийн нэгж хүлээн авч архивын хөмрөгийг бүрдүүлэв. Үүнд байнга ба 70 жил хадгалах 129 ширхэг, түр хадгалах 602 ширхэг цаасан суурьтай хадгаламжийн нэгж, 21 ширхэг DVD, CD хүлээн авч, ангилан цэгцэлж, нэгдсэн дугаар олгон данс, бүртгэл үйлдэн тоо бүртгэлд хамруулсан..	90
48	Арга хэмжээ 4.8. Байгууллагад ирсэн, байгууллагаас явуулсан албан бичгийн эргэлтийг зохион байгуулах	Урсгал зардал	Гүйцэтгэлийг хангасан хувь	90	100	Тайлант хугацаанд байгууллагад 2366 албан бичиг ирж, 1305 албан бичгийг явуулсан. Байгууллагад ирсэн хариутай 621 албан бичгээс 564 албан бичиг шийдвэрлэгдэж, 57 албан бичиг шийдвэрлэх шатандаа байна. Хариугүй 1745 албан бичиг ирсэн болно. Байгууллагаас гадагш явах 1305 албан бичигт дугаар олгож бүртгэл үйлдэн, холбогдох газарт хаяглан хүргүүлсэн бөгөөд үүнээс 450 албан бичгийг шуудангийн ажилтанд хүлээлгэн өгч, цахимаар 707, гарт олгосон 148 албан бичиг байна.	90
Үнэлгээ: 87.1 хувь							


Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин		Хэрэгжилт	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа	Биелэлтийн хувь
				эхний хагас жил	сүүлийн хагас жил				
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Арга хэмжээ 1. Удирдлагын академиас зохион байгуулсан цахим сургалтад хамрагдах ("Монгол бичиг" 1, 2, 3 түвшний сургалт)	сертификатын огноо, дугаар	0	1	2	Төрийн албан хаагчдад зориулан Удирдлагын академиас боловсруулсан "Монгол бичиг"-ийн 1-р түвшний цахим сургалтад 06 дугаар 09-ний өдөр хамрагдаж есгэжрвю дугаар "Үнэмлэх" авлаа.	2025.01	2025.12	100
2.	Арга хэмжээ 2. Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх А3 сургалтад хамрагдах	сертификатын огноо, дугаар	0	1	0	Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх А3 сургалтад хамрагдаж 01 дүгээр сарын 30-ны өдрийн 2025/0545 дугаар сертификат авсан. Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 04 дүгээр сарын 02-ны өдрийн А/161 дугаартай тушаалын дагуу Бүгд Найрамдах Солонгос Улсын Олон Улсын Хамтын ажиллагааны байгууллага (КОЙКА)-аас Сөүл хотноо зохион байгуулсан "Монгол Улсын Гадаадын иргэн, харьяатын газрын хүртээмжтэй үйлчилгээ, менежментийн чадавхыг бэхжүүлэх нь (2023-2025) сэдэвт сургалтад 04 дүгээр сарын 14-27-ны өдрүүдэд хамрагдаж сертификат авсан.	2025.01	2025.06	100

Үнэлгээ: 100 хувь

Төлөвлөгөөг үнэлсэн:
ДАРГА
(албан тушаал)

Тэмдэг


.....
(гарын үсэг)

Төсвийн шууд захирагч
Н.УУГАНБАЯР

(огноо)

.....

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
АУДИТЫН ХЭЛТСИЙН ДАРГА
(албан тушаал)


.....
(гарын үсэг)

Нэгжийн дарга
З.ӨНӨРСАЙХАН/
(огноо)

2025.06.18

Тайлагнасан:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА
(албан тушаал)


.....
(гарын үсэг)

Нэгжийн дарга
И.БААТАРХҮҮ
(огноо)

2025.06.18.

